



ХЭНТИЙ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 10 сарын 03 өдөр

Дугаар А/25

Хэрлэн сум

Тусгай зөвшөөрөл сунгах, түдгэлзүүлэх,
хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2, Зөвшөөрлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5, 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 53 дугаар тогтоолын 5.8 дахь заалт, Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгох комиссын 2023 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийн хугацааг сунгасан байгууллагын нэрсийг хавсралтаар баталсугай.
2. Бор-Өндөр суманд үйл ажиллагаа явуулж буй “Монжура” ХХК-ийн эмэгтэйчүүдийн үүдэн эмнэлэг, Дадал суманд үйл ажиллагаа явуулж буй “Амирлангуй арвижих” ХХК-ийн эмийн сангийн тусгай зөвшөөрлийг тус тус 2023 оны 10 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн 3 сарын хугацаанд түдгэлзүүлсүгэй.
3. Хэрлэн суманд үйл ажиллагаа явуулж буй “Дөрвөн улирал” ХХК-ийн эмийн сан, Бор-Өндөр суманд үйл ажиллагаа явуулж буй “Эм Эн Ар Эл” ХХК-ийн шүдний үүдэн эмнэлэг, Хэрлэн суманд үйл ажиллагаа явуулж буй “Мөнхзол заяа” ХХК-ийн “Амин чулуу” шүдний үүдэн эмнэлгийн тусгай зөвшөөрлийг 2023 оны 10 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн тус тус хүчингүй болгосугай.
4. Дээрх байгууллагуудын үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламжийн хэлтсийн дарга (Х.Доржханд), Эмнэлгийн тусламжийн хэлтсийн Эмийн чанар, аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн (О.Энх-Уянга) нарт үүрэг болгосугай.
5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ мэдээллийн хэлтсийн дарга (Д.Наранмичид)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Л.МЭНДБАЯР

Эрүүл мэндийн газрын
даргын 2023 оны 10 дүгээр сарын
03 өдрийн 4/2 тоот тушаалын хавсралт

**Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай
зөвшөөрлийн хугацааг сунгасан байгууллагуудын нэрс**

№	Тусгай зөвшөөрөл эзэмшиж буй байгууллагын нэр	Тусгай зөвшөөрөл сунгасан хугацаа	Хүчинтэй хугацаа
1	Хэрлэн сумын "Монос Хэнтий" ХХК-ийн эмийн сан	3 жил	2023.10.21-2026.10.21
2	Өмнөдэлгэр сумын "АНЭС фарм" ХХК-ийн эмийн сан	3 жил	2023.09.28-2026.09.28
3	Мөрөн сумын "Их Мөрөн Шүүдэргэнэ" ХХК-ийн эмийн сан	3 жил	2023.09.28-2026.09.28
4	Хэрлэн сумын "Шөнхоон" ХХК- ийн эмэгтэйчүүдийн үүдэн эмнэлэг	3 жил	2023.10.21-2026.10.21
5	Батширээт сумын "Бөөн шинэс" ХХК-ийн эмийн сан	3 жил	2023.09.28-2026.09.28